

ВАК СУРГАЛТЫН АРГА ЗҮЙГ НЭВТРҮҮЛЭХ ТУРШИЛТ СУДАЛГАА

Б. Энхцацрал
Оюуны ирээдүй цогцолбор
enkhstsatsral6784@gmail.com

Хураангуй

Боловсролын эцсийн зорилго нь нийгмийн дотор амьдрах, сурах, хөгжих аргад сургах, төрөлхийн авьяас чадвараа хөгжүүлэх боломжийг нь нээж өгөхөд оршино. Энэ нь тухайн хүний /суралцагчийн/ байгалиас заяасан аливаа зан чанар, чадвар, мэдрэмж, суралцах хэв шинж онцлог зэргийг сургах үйл явцад оношлон, түүнд тохирсон жор арга зүйгээр сургалтын процессийг удирдан явуулна гэсэн үг билээ. Суралцах хэв шинжийн талаар хэд хэдэн төрлийн загваруудыг дэлхийн улс орнуудад ашиглаж байна. Эдгээр загваруудыг 3 бүлэгт хуваадаг. 1. Үйл ажиллагаанд чиглэсэн (сурах үйл), 2. Бие хүний төлөвшлийн онцлогт чиглэсэн, 3. Танин мэдэхүйд чиглэсэн. Танин мэдэхүйд чиглэсэн загварт Н.Флемингийн боловсруулсан ВАК загвар багтана. Н.Флемингийн ВАК загвараар тухайн суралцагч шинэ зүйлд суралцахдаа ямар мэдрэхүйн эрхтэнээрээ мэдээллийг илүү үр дүнтэйгээр хүлээн авдаг болохыг тодорхойлдог. Энэхүү загварын дагуу суралцагчдын суралцах хэв шинжийг харааны (V – visual), сонсголын (A – auditory), хөдөлгөөний (K – kinesthetic) болон холимог гэж ангилдаг. ВАК сургалтын арга зүй, технологийн гол онцлог нь суралцагчдынхаа ой тогтоолт, сурч танин мэдэх хэв шинж, оюуны чадамж, анхаарлын төвлөрөл, судлах агуулгын талаар амьдрал дээрх мэдлэг ойлголтыг илрүүлэх судалгааг хийж, хүүхэд нэг бүрт тохирсон арга зүйгээр сургалтыг зохион байгуулдагт оршино. Туршилт судалгаандаа гадаадын эрдэмтэн судлаачдын “Children’s learning styles”, “Технология личностно-ориентированного обучения” буюу сурах арга барилыг тухайн хүнд заяасан төрөлхийн чанар, чадавх, мэдрэмжүүдтэй холбон судлах хандлага, онолыг үндэс болгон, сурах арга барилыг ВАК загвараар оновчтой тодорхойлох замаар хөгжүүлэх боломжтойг батлах оролдлого хийсэн болно.

Түлхүүр үг. Бие хүний төрөлхийн чадамж, ялгаатай байдал, ялгаатай хандах арга зүй, суралцах хэв шинж

Үндсэн хэсэг

ВАК сургалтын арга зүйн мөн чанар, үзэл санаа: Эрдэмтэн судлаачдын үзэж байгаагаар жинхэнэ боловсрол нь хүнд ямар нэгэн зан төлөв, шинэ зан чанарыг гаднаас нь нэмж олгох бус, харин төрөлхийн авьяас чадварыг нь хөгжүүлэх үүрэгтэй байдаг байна. Энэ ч үүднээс сүүлийн жилүүдэд боловсролын салбарт гарч буй шинэ шинэ ойлголт, үзэл санаанууд нь бусад салбаруудад гарч буй ололт, амжилт, нээлтүүдтэй уялдаж буй байна.

Хүний “төрмөл” хэмээх ойлголтонд яахын аргагүй танин мэдэхүйн хэв шинж хамаарна. Энэ тухай барууны орны алдартай эрдэмтэн, судлаачид нилээд эртнээс олон янзын байдлаар судалсан байдаг бөгөөд сүүлийн жилүүдэд манай ойрын хөрш болох Оросын эрдэмтэн судлаачид “Технология личностно-ориентированного обучения” (хүснэгт 1) хэмээх технологийг сонирхон судлах болжээ. Тухайлбал, хувь хүний болон бие хүний төрөлхийн суурь чадамжуудыг сурган, сэтгэл зүйн талаас нь хэд хэдэн ойлголт, зарчим, арга барилыг тодорхойлсон байна. Эдгээр онолыг үндэслэгчдээс дурьдвал К. Гольдштейн, А. Маслоу, Дж. Олпорт, К. Роджерс, Э. Фром, Г.А. Балл, И.Д. Бех, Р.С. Гуревич, В.В. Давыдов, И.А. Зязюн, А.С. Макаренко, В.А. Моляко, Н.Г. Ничкало, А.В. Петровский, В.А. Сухомлинский, Б.А. Федоришин, И.С. Якиманская зэрэг эрдэмтэн судлаачид болно.

Хүснэгт 1.

Харьцуулсан үзүүлэлтүүд	Сургалтын технологи	
	Уламжлалт	Хувь хүнд чиглэсэн хандлагын технологи
Зорилго	Урьдчилан тодорхойлсон шинж чанар бүхий хувь хүний бүтцийг бий болгох	Хувь хүний хөгжлийг амьдралын болон хүний сэдэв гэж үздэг
Сургалтын үүрэг	Сургалтын зорилгыг хангах	Хувь хүний хөгжлийг хангах
Суралцагчийн байр суурь	Сургалтын үйл явцын объект	Сургалтын үйл явцын субъект
Үндсэн дидактик үйл ажиллагаа	Ганцаарчилсан, мэдлэг, үр чадвар эзэмших	Харилцан яриа, олон талт хамтын ажиллагаа, танин мэдэхүйн болон бүтээлч үйл ажиллагаа
Хэтийн зорилго	Нийгмийн болон үйлдвэрлэлийн хэрэгцээг хангах	Хувь хүний хэрэгцээ, сонирхлыг хангах
Багшийн үйл ажиллагаа	Мэдлэгийн эх сурвалж, зохицуулагч	Зохицуулагч, зөвлөх, туслах, зохион байгуулагч (менежер)
Сургалтын үр дүн	Сурч, нийгэмшин тодорхой түвшинд хүрсэн байх	Хувь хүний хөгжил, боловсролын үнэ цэнэ, өөрийгөө илэрхийлэх түвшин


“Хувь хүн, бие хүний төлөвшлийн онцлог” – ийн үзэл баримтлал, онолын зорилго бол боловсролын үйл явцыг хөгжүүлэх хувь хүний хөгжлийг хангах бодит нөхцөл байдлыг илрүүлэх явдал юм. Уламжлалт сургалтанд хувь хүнд чиглэсэн хандлагын технологи нь өөр өөр арга зүй, технологи болж хувирсан байдаг.

2004 онд Лондонгийн Ньюкэстлийн их сургуулийн профессор Коффилдоор ахлуулсан эрдэмтдийн баг сурах арга барилын талаар судалгаа хийж, XX зуунаас өнөөг хүртэл энэ чиглэлээр 71 онол гарсан байдгийг тогтоосон байна. Онол практикийн ач холбогдол ихтэй энэхүү судалгааны ажлын үр дүнд сурган хүмүүжүүлэх практикт үр дүнтэй нь батлагдсан 13 загварыг илрүүлэн гаргажээ.

Хүн аливаад суралцах, танин мэдэх 3 үндсэн (Visual – learn through seeing, Auditory – learn through hearing, Kinesthetic - learn through doing and moving) хэв шинж байдаг гэдгийг барууны эрдэмтэд 1970-аад оноос тодорхойлсон байдаг, үүнд аль нэгийг нь нөгөөгөөс нь давуу, эсвэл зөв, буруу, сайн, муу гэж авч үзэх ойлголт байхгүй ба үүнээс хамаарч сурах арга барил нь ч мөн өөр өөр байна. Сурган хүмүүжүүлэгч бид хичээл зааж буй шавь нарынхаа, цаашлаад анги тус бүрийн сурах арга барилын онцлогийг танин мэдсэнээр сургалтын арга зүйгээ оновчтой сонгон, тэдэнд илүү хүртээмжтэй байдлаар сургалтыг зохион байгуулж, суралцагч нэг бүрийн ялгаатай байдлыг харгалзан үзсэн, тэдний хөгжлийг хангасан сургалтын чиг хандлагыг тодорхойлж, Монголын боловсролын шинэчлэлд хувь нэмрээ оруулж болох юм.

Хүний тархи олон янзын орчинд ажиллах, олон төрлийн дохионуудыг боловсруулахад программчилагдсан байдаг ба хүлээн авах, бодох ба сурах аргуудын хооронд их ялгаа байдаг. Үүний шалтгаан нь хүн бүрийн тархины бүтэцдээ өөр өөр хүлээн авах ба сурах системтэй байдагтай холбоотой. Хатуу хальсан бүрхүүлтэй хагас килограмм орчим жинтэй хүний энэхүү нандин эрхтэн гайхамшигтай амьд санах байгууламж юм. Когнитив судлаачид хүний ой тогтоолт хосолмол шинжтэйг тогтоож, түүний бүтцийг богино хугацааны ой, урт хугацааны ой гэсэн хоёр хэсгээс бүрддэг гэж үздэг. Уураг тархи судлалын онолуудад баруун, зүүг хоёр тархины чадвар ялгаатай бөгөөд чухам аль тархины үйл ажиллагаа давуу байгаагаас хамаарч хүний зан үйл болоод сэтгэл зүй цаашлаад суралцах хэлбэр зэрэг нь тодорхойлогддог болохыг томъёолсон байдаг.



Зураг 1. Тархины ерөнхий үйл ажиллагаа



Амьдралд болдог зүйлүүдийг харахад хүмүүсийн зарим нь чимээ, шуугиан, зарим нь мэдэрсэн мэдрэмж, зарим нь үнэр болон амтыг илүүд үздэг. Хүн тэгэхээр өөрийнхөө илүүд үздэг мэдрэмжээрээ мэдэрч, тархиндаа дохио өгдөг. Тархи нь болсон үйл явдал, ирсэн дохиогоор мэдлэгийг бий болгодог. Энэ байдал нь хүний сурах болон санах систем нь өөр өөр байдгаас хамааралтай. Хүний сурах болон цээжлэх системийг мэдэх нь сурахыг хялбар болгон, ой ухаанд тогтоохыг илүү хүчтэй болгоно. Үнэндээ хүн өөр өөр байдлаар хүлээн авах, сурах системтэй болохын зэрэгцээ, хүн бүр эдгээрийнхээ нэгэнд нь илүү сайн байдаг. Өөрөөр хэлбэл зарим хүмүүсийн харах, зарим хүмүүсийн дуу авиаг, зарим нь мэдрэх мэдрэмж нь илүү хөгжсөн байдаг. Хэрэв эдгээрт өөр өөр нэр өгөх хэрэгтэй бол, эхний хэсэг хүмүүст “дүрсний мэдрэмж хөгжсөн тархи”, харааны ой санамж сайтай хоёрдахь бүлэгт багтах хүмүүсийг “дууны мэдрэмж илүү хөгжсөн тархи”, сонсох ой санамж сүүлийн хэсэг хүмүүст “хүрэх мэдрэмж илүү хөгжсөн тархи” гэж нэрлэж хувааж болно.

Visual – Auditorium – Reading writhing – Kinesthetic сургалтын загвар нь хүний давуу эсвэл давамгайлсан сэтгэлгээ, суралцах хэв шинжид тулгуурладагаараа өөр бусад суралцах хэв шинжээс давуу талтай юм. VAK-ийн хэв шинжид үндэслэсэн онолын дагуу бидний мэдрэх мэдрэмжийн нэг буюу хоёр нь давамгайлж байдаг бөгөөд суралцагчдын суралцах арга барилын хувьд төрөлхийн давуу талууд байдаг гэж үздэг. Тиймээс суралцагсдын хэрэгцээг илүү үр дүнтэйгээр шийдвэрлэн суралцагчдын сурах арга барилыг сайжруулахын тулд хэв шинжид тохирох аргыг хослуулан хэрэглэх нь зүйтэй юм. VAK-ийн сургалтын онолын үндсэн үнэ цэнэ нь хүмүүсийг өөр хоорондоо ялгаатай суралцдаг талаар бодоход хүргэн сургалтын аргуудыг янз бүрээр нэгтгэж, боловсруулан олон янзын сургалтын орчинг бий болгож эхэлдэгт оршино. Энэхүү танин мэдэх хэв шинж нь өөр өөрийн гэсэн харилцан ялгагдах өвөрмөц онцлогтой.

Зураг 2. Баруун, зүүн тархины танин мэдэх хэв шинжийн харьцуулалт



Visual хэв шинж. Зураг, диаграм, жагсаал, гарын авлага, видео бичлэг, график, бичсэн үг гэх мэт зүйлсийг үзэх, ажиглах дуртай, харагдах байдал, ажиглалтын зүйлсийг илүүд үздэг ба санах чадвар өндөр байдаг. Эдгээр хүмүүс зааврыг

уншсаны дараа шинэ ажил хийх хамгийн сайн чадвартай байдаг. Тэд гар утсаа байнга хэрэглэдэг бөгөөд ярихдаа дээш харах хандлагатай байдаг. (Pritchard, 2009) Visual суралцагчдад хэлний болон орон зайн гэсэн хоёр дэд хэлбэр байдаг ба унших, бичих гэх мэтээр суралцдаг. Тэд хэдийгээр уншаагүй ч гэсэн бичсэн зүйлийг санаж байна. Тэд зааврыг бичиж, лекц уншиж байгаад анхаарлаа хандуулахыг хүсдэг. Visual-орон зайн суралцагчид ихэвчлэн бичгэн хэл дээр хүндрэлтэй диаграм, жагсаал, видео бичлэг болон бусад харааны материалууд дээр илүү сайн ажилладаг. Visual суралцагч нар харах, унших, бичих, зурах, бичсэн зааварчилгааны дагуу хамгийн сайн суралцдаг ба танилцуулга хийхэд сэтгэл хангалуун бус байдаг. Зарим харааны суралцагч нар ширээн дээрх хэвлэмэл материал дээр ч тэмдэглэл хөтөлж байдаг. Visual суралцагчдын ойролцоогоор хүн амын 65% -ийг бүрдүүлдэг. Тэдний төсөөллийг ашиглан аливааг амархан дүрслэх боломжтой.

Аудио хэв шинж. Ийм суралцагчийн сонсох чадвар нь түлхүү хөгжсөн байдаг тул сонсож ойлгох дасгал, даалгаврыг амжилттай гүйцэтгэдэг. Эхийг чангаар дуудан унших, бусад хүний ярьж байгааг сонсох, хүмүүстэй харилцах дуртай, цээжлэх ой тогтоолт маш сайтай, аман даалгаврыг төвөггүй биелүүлдэг, гадны дуу чимээнд анхаарал нь амархан сарнидаг. Тэдний дуртай дасгал, даалгаврын төрөлд сонсох дасгал, харилцан яриа, ярилцлага зэрэг орно. Эдгээр хүмүүс “надад хэлээч”, “хамтдаа ярилцъя” гэх мэт үгүүдийг ашиглах бөгөөд багшийн өгсөн зааврыг сонссоны дараа даалгавар хийх боломжтой болдог. Хөгжмийн багш нар сонсох замаар суран эргэн санах өндөр чадвартай байдаг. Эдгээр суралцагчид өөрсдийн анхаарлаа төвлөрүүлэх, эсвэл эргэн санах үед нүдний хөдөлгөөнийг багасгах хандлагатай байдаг (Pritchard, 2009). Тэдний хувьд унших, бичих нь бэрхшээлтэй байдаг бөгөөд ихэвчлэн хамтрагчтайгаа ярилцах эсвэл дуу хураагчаас юу ярьж буйг нь сонсдог.

Кинестетик хэв шинж. Кинестетик - гэсэн үг нь булчингийн хөдөлгөөнийг ашиглах мэдрэмжийг илэрхийлдэг, өөрөөр хэлбэл биеийн мэдрэмж. Kinesthesia болон kinesthesia үгийн үндэс нь Грекийн kineo гэсэн хэлнээс гаралтай юм. Тиймээс Kinesthetic – ийг биеийн булчингууд, үе ба шөрмөс нь мэдрэлийг өдөөдөг сургалтын хэлбэр хэмээн тайлбарладаг. Энэ нь ‘touchy-feely’ (‘kineo-aisthesis’ = ‘шилжих мэдрэхүй’ гэсэн утгатай) илэрхийлэлтэй холбоотой. Энэ хэв шинжтэй суралцагч нь ширээний ард сууж уншиж, бичих юм уу ярих даалгавар гүйцэтгэхийн оронд аль болох биеийн идэвхтэй, хөдөлгөөн шаардсан тухайлбал, тоглоом тоглох, жүжигчилсэн тоглолт хийх, ямар нэгэн зүйл угсарч эвлүүлэх гэх мэт идэвхтэй дасгал, даалгаврыг хийж гүйцэтгэх хүсэлтэй байдаг. Тиймээс ч тэдэнд багш төвтэй уламжлалт хичээлд удаан цагаар ширээний ард суух уйтгартай бөгөөд хүндрэлтэй. Эдгээр хүмүүс “Та оролдоод үзээрэй”, “чи юу мэдэрч байна?”

гэх мэт хэллэгийг ашиглана. Тэд туршилт хийх дуртай ба зааврыг нь хэзээ ч хардаггүй хүмүүс юм. Kinesthetic суралцагчид суралцахын тулд хийж гүйцэтгэх, дадлагажуулах, эсвэл хийж буй үйл явдлыг төсөөлөн боддог. Тэд суралцах орчинд, ялангуяа бодит үйл явдлын мэдрэмжтэй холбоотой үйл явдлын үед мэдээллийг эргэн санах ба санах ой нь бие махбодтойгоо харилцан хамааралтай байдаг. Kinesthetic суралцагч нар кинетик (хөдөлгөөн) ба хүрэлцэхүй (мэдрэгчтэй) гэсэн хоёр дэд хэсэгт хуваагддаг. Тэд гадны нөлөөнд автдаггүй, хөдөлгөөнгүй байвал төвлөрөл алдагдах хандлагатай байдаг. Лекцийг сонсохдоо гараа хөдөлгөхийн тулд тэмдэглэл хийхийг хүснэ. Уншиж байхдаа материалд эхлээд хайлт хийн дараа нь нарийн ширийн зүйлийг анхааралдаа авдаг. Ихэвчлэн өнгөт, том, амархан зураг, диаграмм, хүснэгтэн зургуудыг зурж тэмдэглэдэг. Лабораторийн ажил, хээрийн аялал, төсөл, туршилт, бодит амьдралын жишээнүүдэд дуртай. Хичээлийн агуулга ихэнхдээ тэдний сурах арга барилд нийцэхүйц хэв шинжээр танилцуулагддаггүй тул кинестетик хэв маяг нь удаан гарч ирдэг. Кинестетик суралцагчид нийт хүн амын 5% орчмыг бүрдүүлдэг

Хүмүүст сургалтын аль нэг хэв маяг голчлон илэрдэг боловч зарим хүмүүс маш их давуу талтай холимог хоёр буюу заримдаа гурван хэлбэртэй ч байдаг. Та өөрийн сургалтын хэлбэрийг тодорхойлсоноор өөрт тохирох сургалтын хэв шинжийг мэдэж авна. Зөв, буруу сургалтын хэв шинж гэж байхгүй бөгөөд хамгийн гол нь суралцах хэлбэрүүд нь таны сурах арга

Судалгааны арга

1. Бүтэцлэгдсэн анкетын арга
2. Баримт бичгийн шинжилгээ (2.1) Контент анализ – хувь хүний хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны үр дүн ба баримт бичиг, мэдээлэлд анализ хийх арга
3. Ажиглалтын арга
4. Туршилтын арга (4.1) Төлөвшүүлэх туршилт – сэтгэцийн аль нэг тал, шинж байдлыг өөрчлөн хөгжүүлэх явцдаа судлах
5. Чанарын судалгааны арга
6. Математик загварчлал

Судалгааны загвар /арга зүй/ хандлага

1. Туршилтын бүлгийн суралцагчдын сурах хэв шинжийг тодорхойлон улмаар бие хүний төрөлх танин мэдэх хэв шинж анги ахин төлөвшихийн хирээр өөрчлөгддөг эсэхийг илрүүлэх
2. Суралцагчдын сурах хэв шинжид тохируулан дасгал, даалгаврыг ялгаатай байдлаар боловсруулан турших
3. VAK сургалтын арга зүйг нэвтрүүлэх туршилтат хичээлүүдийг зохион байгуулж, үр дүнд дүн шинжилгээ хийн санал дүгнэлт боловсруулах

Үндэслэл

Орчин үеийн сургалтын арга, технологи нь хүн бүрийн сурах чадвар, нөөц бололцоо ялгавартайг хүлээн зөвшөөрсөн хүн төвтэй сургалтын арга байх бөгөөд суралцагчийг ёроолгүй хоосон сав гэж үзэж “мэдлэгээр дүүргэх” аргаар сургах практикаас татгалзаж, хүүхэд залуусыг байгалиас өөртөө авч төрсөн их чадавхитай бөгөөд тасралтгүй бие даан сурах арга барил эзэмшүүлэхэд чиглэн чадвар, чадамжинд суурилсан байх юм. Энэ ч үүднээс хувь хүний оюуны хөгжлийн үе шат, сурахуйн хэв шинж, арга барил зэргийг судалдаг когнитив конструктивизмын үзэл баримтлалд тохирох VAK сургалтын арга зүйг туршиж судлан боловсролын чанарт гүйцэтгэх үүргийг тодорхойлох нь судалгааны ажлын үндэслэл болно.

Судалгааны үр дүн

1. Суралцагчдын сурах хэв шинжийг тодорхойлох судалгааны үр дүн

Судалгаанд 2014 онд 7-р ангийн 253 суралцагч, 2017 онд 9, 10-р ангийн нийт 181 суралцагч тус тус хамрагдсан бөгөөд сурах танин мэдэх шинжийг сүүлийн судалгааны дүнд үндэслэн тус бүрээр авч үзвэл 42.5% кинестетик, 32% визуал, 30.3% аудио харин үлдсэн 7.1% нь хосолмол хэв шинжтэй байна. Сурах хэв шинж гэдэг ойлголт ихэнх суралцагчдад давамгайл, харин холимог хэв шинж харьцангуй бага илэрч байна. Энэ нь хүнд аль нэг танин мэдэх хэв шинж 100% дангаараа давамгайлдаггүй гэдгийг суралцагч бүрийн хариултанд хийсэн дүн шинжилгээнээс харж болно.

2. VAK сургалтын арга зүйн туршилтат хичээлийн үр дүн

Суралцагчдын сурах хэв шинжийг Н.Флеймингийн боловсруулсан сорилоор тодорхойлон анги бүрийн онцлогт тохируулан боловсруулсан арга зүй бүхий сургалтаар ээлжит хичээлийг зохион байгуулан дараах дүгнэлтийг хийлээ.

1. Суралцагч та энэ өдрийн хичээлийг ямар түвшинд ойлгосон бэ? гэсэн 1-р асуултанд хариулсан байдлыг авч үзвэл, нийт 89 суралцагчийн 44 нь буюу 49,4% нь агуулгыг маш сайн ойлгосон, 35 нь буюу 39.3% нь ерөнхийдөө ойлгосон боловч зарим нэг зүйлийг лавлах шаардлагатай, 10 нь буюу 11,2% нь огт ойлгоогүй биш боловч дахин судлах шаардлагатай гэж тус тус хариулжээ. Асуулгын огт ойлгоогүй гэсэн хариулт аль ч ангид сонгогдоогүй байгаа нь бидний боловсруулсан арга зүйн төлөвлөлт сургалтын дидактик шаардлагад нийцэж байна хэмээн дүгнэж болохоор байна.
2. Суралцагч та энэ өдрийн хичээлд хэрхэн оролцож ямар үйл ажиллагаа хийсэн бэ? гэсэн 2-р асуултанд хариулсан байдлыг авч үзвэл нийт 24.2% - харилцан ярилцах санал бодлоо солилцох, үзэл бодлоо

илэрхийлэх шүүмжлэх, 18.3% - бичих тэмдэглэх зурах, 19,1% - идэвхтэй унших, 12,1% - харьцуулах жиших дүгнэх, 5,8% - самбарт ажиллах, 5% - шалгах хянах бусдад зааж зөвлөх, 15,2% - асуултанд хариулах хэмээн өөрийн сургалтын үйл ажиллагааг үнэлсэн байна. Асуултын өгөгдсөн хариултуудаас сонгогдоогүй хариулт байхгүй байгаа нь сургалтын арга зүйн төлөвлөлт суралцагч бүрийн онцлогийг харгалзан үйл ажиллагаанд хамрагдаж байхаар төлөвлөгдсөн нь харагдаж байна.

Судлаач Н.Флемингийн VAK танин мэдэх хэв шинжийг тодорхойлох сорил болон туршилт судалгааны үр дүн, ажиглалт, сурагч төвтэй сургалтын онол арга зүй, орчин үеийн сургалтын чиг хандлагат тулгуурлан судлаач бид дараах сурах танин мэдэх хэв шинжийг харгалзсан арга зүйн технологийн бүдүүвчийг хувилбар байдлаар боловсруулав.

Хүснэгт 2. Сурах, танин мэдэх хэв шинжид тулгуурлан зохион байгуулах сургалтын технологийн бүдүүвч (хувилбар)

№	Сургалтын элемент	Үзүүлэлт
1	Зорилгоо тодорхойлох	Сургалтын агуулыг бие хүний төрөлх хэв шинжид тулгуурлан эзэмшүүлэхэд чиглэсэн байх Суралцагчийн сурах хэв шинжийн давуу талыг ашиглан сул талыг хөгжүүлэх
2	Арга зүйгээ боловсруулах	Арга зүй нь тогтсон байх шаардлагагүй бөгөөд тухайн ангийн суралцах хэв шинжийн онцлогт тохируулан хүснэгт №. дэвшүүлсэн арга зүйн хувилбараас сонголт хийх
3	Сургалтын хэрэглэгдэхүүн	Арга зүйн сонголт, сургалтын агуулга хэлбэрээс хамаарна
4	Ялгаатай байдал	Сурах танин мэдэх хэв шинж
5	Багшийн үйл ажиллагаа	Сонгосон арга зүйн дагуу төлөвлөсөн агуулгаар сургалт явуулах Бие хүнд хандсан харилцааг бий болгох (суралцагчдаа маш сайн судалж мэдсэн байх) Суралцагчдын жигд оролцоонд анхаарах, хянах, чиглүүлэх
6	Суралцагчийн үйл ажиллагаа	Сургалтын турш идэвх оролцоотой байж үйл ажиллагаанд хамрагдах

Дүгнэлт

1. Анги ахиж төлөвшихийн хирээр суралцагчдын сурах хэв шинж илүү тодорхой хэлбэр лүү шилжиж байсан ба энэ нь тэдний бие хүн болон нийгэмшиж буйн илрэл юм. Мөн сурах хэв шинж гэдэг ойлголт төрөлхийн шинж чанартай байдаг гэдгийг ч судалгааны үр дүн, судлаачдын онол баталж байна. Иймээс энэхүү төрмөл шинжийг сургалтын үйл ажиллагаанд тооцон төлөвлөлт, арга зүйгээ боловсруулах нь зүйтэй хэмээн үзэж байна.

2. Суралцагчдын сурах арга барилын онцлогт тулгуурлан ялгаатай байдлаар даалгаврыг боловсруулах, арга зүйгээ төлөвлөх нь сургах – сурах үйл ажиллагааг илүү хялбар болгож, суралцагч нэг бүрийн хөгжлийг жинхэнэ утгаар нь хангах боломжтой бөгөөд сургалтын чанар, үр дүнд ахиц дэвшил гарахыг туршилт, судалгаа баталлаа.

3. Сурах арга барилыг хувь хүний төрөлхийн олон талт чадамжинд суурилан эзэмшүүлэх нь илүү үр дүнтэй, бие хүний онцлогийг харгалзан үзэж дээдэлсэн үйл явц бөгөөд ингэсээр суралцагч өөртөө итгэлтэй, давуу сул чанараа танин мэдсэн ирээдүйд зөв иргэн хүн болон төлөвших хандлагыг бий болгох юм. Иймд бидний туршиж судалсан энэхүү арга зүйн хувилбарыг багш бүр авах гээхийн ухаанаар хандан өөрийн арга зүй, суралцагчдынхаа ялгаатай байдлыг харгалзан сургалтын үйл ажиллагаандаа нэвтрүүлж шинэчлэл хийсэнээр глобальчлагдаж буй өнөөгийн зуунд дэлхийн боловсролын чиг хандлагад нийцсэн сургалт явуулахад суралцах юм.

VAK METHODOLOGY TEST AND CONVEY EXPLORATION

Abstract.

The ultimate goal of education is to teach people how to live, learn, and develop in society, and to develop their innate talents. This means that any natural traits, abilities, feelings, and learning characteristics of a person (learner) are diagnosed in the learning process and the learning process is guided by appropriate recipes. Several models of learning styles are used around the world several models of learning styles are used around the world. These models are divided into three groups. 1. Focus on activities (learning), 2. Focus on personality traits, 3. Focus on cognition. Cognitive models include the VAK model developed by N. Fleming. N. Fleming's VAK model determines which sensory organs are most receptive to information when a learner learns something new. According to this model, students' learning styles are classified as visual (V - visual), auditory (A - auditory), motor (K - kinesthetic) and mixed. The main feature of VAK's teaching methodology and technology is that it conducts research to find out the students' memory, cognitive patterns, intellectual abilities, concentration, and learning content in real life, and organizes the training according to the methodology suitable for each child. The experimental research is based on the approaches and theories of foreign scholars to study "Children's learning styles" and "Technology of personal-oriented learning" in relation to the innate qualities, abilities and feelings of a person and an attempt has been made to prove that learning methods can be developed using the VAK model.

Зохиогчийн тухай.

Баясгалангийн Энхцацрал нь 2005 онд МУБИС-ийг Экологи-химийн багш мэргэжлээр дүүргэсэн. Дархан – Уул аймгийн ЕБ-ын лаборатори Оюуны Ирээдүй цогцолбор сургуульд химийн багшаар ажилладаг бөгөөд 2015 оноос ШУТИС-ийн доктор Д. Баясгалангийн удирдлаган дор сургалтын арга зүйн шинэчлэл буюу сургах, сурах арга барилын талаар судалгаа хийж байгаа болно. 2018 онд 3 жилийн судалгааны ажил болох “VAK сургалтын арга зүйг нэвтрүүлэх туршилт судалгаа”-аар магистрийн зэргийг хамгаалсан.

Ном зүй

1. Ананьев Б.Г.(1957) О развитии детей в процессе обучения. Советская педагогика
2. Батсайхан Б. Дэлгэржав М. (2013) Ерөнхий сэтгэл судлал. УБ
3. Бэгз Н. (2013.) Монголын боловсрол судлалын шинэ парадигм. УБ
4. БСШУЯ, (2017) From the people of Japan, Save the children.,Багш эцэг эхтэй харилцах дэвтэр. УБ,
5. БСШУЯ, БМДИ., (2014) Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй. УБ
6. Под ред. В.А.Крутецкого. М, (1964) Вопросы психологии способностей школьников.
7. Ичинхорлоо Ш. Долингор Г. (2005) Сургалт, УБ
8. Ичинхорлоо Ш. (2009) Сургалтын арга зүйн шинэчлэл. УБ
9. Ичинхорлоо Ш. (2012) Сургалтын онол, хэрэглээ. УБ
10. Ичинхорлоо Ш. (2012) Сургалтын технологи. УБ
11. Мэндбаяр Д. (2011) Сургалтыг хөтлөн явуулах арга зүй, ур чадвар. УБ
12. Пүрэвдорж Ч. Багшлахуйн менежмент. УБ
13. Пүрэвдорж Ч. (2014) Тогтолцооны хандлага ба боловсрол судалгаа. УБ
14. Якиманская И. С. (1979) Развивающее обучение. М.,
15. Оюунтунгалаг О. Алимаа Б. Даалгавараар сурагчдын оролцоог хангаж, сурах үйлийг дэмжих арга зүйн судалгаа
16. Должинсүрэн Б. Сувдаа Т. Энхзаяа Г., ТТДС-ийн МБС-ийн I ангийн суралцагчдын